



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Монголын Либерал Ардчилсан нам
(МоЛАН)-ын дарга өөрчлөгдсөнийг
бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын дарга өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Д.Мөнхтуяагийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Анхбаяраас "... Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын дарга Б.Өлзийдүүрэн нь намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Иймд манай нам нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 29 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан дүрмийн дагуу хуралдаж, 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын даргыг шинээр сонгосон тул намын даргын өөрчлөлтийг Улс төрийн намын тухай хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгэж өгнө үү" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын дарга өөрчлөгдсөнийг бүртгэж шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзэв.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 29 дүгээр тогтоолд "... Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 004 дүгээр тогтоолоор тус намын Их чуулганы 2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 08/006 дугаар тогтоолоор түр шилжүүлсэн эрхийн дагуу намын Бүгд хурлын гишүүдийн бүрэн эрхийг улираан батламжилж, улмаар 005 дугаар тогтоолоор тус намын дүрэмд нэмэлт оруулахаар шийдвэрлэжээ. Тус намаас 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн өргөдөлд нэмж ирүүлсэн баримт болох Ээлжит бус Их чуулганы 2008 оны 04 дүгээр сарын 04-ний

өдрийн 08/005 дугаар тогтоолоор сонгогдсон Бүгд хурлын 70 гишүүнээс 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Бүгд хурлаар Бүгд хурлын 60 гишүүний бүрэн эрхийг улираан батламжилсан байна. ... Иймд Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 005 дугаар тогтоолоор тус намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тус намын дүрмийн 3.7.9.7 дахь заалт болон Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т нийцсэн байх тул нийт шүүгчийн хуралдаанаас улсын бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж шийдвэрлэв” гэжээ.

Түүнчлэн, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 33 дугаар тогтоолд “... “Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 29 дүгээр тогтоолд “Тус намаас 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн өргөдөлд нэмж ирүүлсэн баримт болох Ээлжит бус Их чуулганы 2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 08/005 дугаар тогтоолоор сонгогдсон Бүгд хурлын 70 гишүүнээс 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Бүгд хурлаар 60 гишүүний бүрэн эрхийг улираан батламжилсан байна” гэж заажээ. Монголын Либерал Ардчилсан намын 2023 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн Бүгд хурлын товыг 60 гишүүнд мэдэгдсэнээс, 47 гишүүн оролцож намын дарга Т.Төмөрмөнхийг огцруулж, Б.Өлзийдүүрэнг сонгосон нь олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх зарчимд нийцсэн байна” гэж дүгнэж, тус намын даргаар Б.Өлзийдүүрэнг сонгосныг бүртгэсэн байна.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаас үзвэл, Монголын Либерал Ардчилсан намын дарга Б.Өлзийдүүрэн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр “... хувийн шалтгааны улмаас цаашид намын ажилд оролцох боломжгүй болсон. Иймд Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын даргын үүрэгт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтэй байна. Намын дүрэм журмын дагуу шийдвэрлэж өгнө үү” гэх хүсэлт гаргасан, уг хүсэлтийг тус намын Бүгд хурал 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцэж, хуралд оролцсон нийт 54 гишүүний 100 хувийн саналаар намын даргын үүрэгт ажлаас Б.Өлзийдүүрэнг чөлөөлж, намын даргаар Д.Пүрэвдавааг сонгох тухай 06 дугаартай тогтоол баталсан нь тухайн намын Бүгд хурлын эрх хэмжээнд байна гэж үзэв.

Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын дүрмийн 3.7.9 дүгээр зүйлийн 1-д “Намын Бүгд хурал дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ”, 3.7.9 дүгээр зүйлийн 14-т “Бүгд хурлаас намын даргыг а.Сонгуулийн үр дүнгээр огцруулах, сонгох, б.өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх, сонгох” гэж тус тус заасны дагуу намын даргыг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлөх болон намын даргыг сонгох эрх нь намын Бүгд хуралд олгогдсон байна.

Улс төрийн намын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Нам нь намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагатай байна” гэж, 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх ... “-ээр тус тус заасан, энэ тохиолдолд Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын Бүгд хуралд нийт 81 гишүүний 66.6 хувь нь оролцож, хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дээрх шийдвэрийг гаргасан нь уг хууль болон тус намын дүрмийн 3.7.9 дүгээр зүйлийн 14-т заасантай нийцсэн гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын даргаар Д.Пүрэвдавааг бүртгэсүгэй.

2. Монголын Либерал Ардчилсан намаас Улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг төрийн сангийн 100200700941 тоот данснаас буцаан олгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА